

ЗӨВ ХҮН, ЗӨВ БАГШИЙГ ХӨГЖҮҮЛЖ ТӨЛӨВШҮҮЛЭХ АСУУДЛЫН ТУХАЙ

Н.Тэгшжаргал
Дархан дээд сургууль
tegsh2511@gmail.com

Хураангуй

XXI зуунд дэлхийн олон орон боловсролын бодлогоо багш төвтэй мэдэхүйн парадигмаас суралцагч төвтэй хүмүүнлэг боловсролын парадигмад шилжиж, хүмүүнлэг хөгжлийн шинэ чиг хандлага болгон өөрчилж байна. Энэ чиг хандлага нь шинэ зууны иргэний нийгэмд ажиллаж амьдрах иргэн бүхэнд хүмүүнлэг ёс суртахуун, ёс зүй нь соёл, боловсролоор дамжин иргэний нийгмийн мөн чанар болон төлөвшиж нийгэмшдэг. Зөв Монгол хүүхэд гэж хэн бэ? гэдгийг шинээр томьёолж, зөв сэтгэлтэй хүн төлөвших үйл явцад тулгарч байгаа бэрхшээл, алдааны шалтгаан, түүнийг даван туулах арга замын талаар боловсролын ажилтан, багш нарт саналаа солилцох зорилгоор хөндөв.

Түлхүүр үг: Зөв хүн, зөв мэргэжилтэн, зөв сэтгэл, нийгмийн чадвар

Оршил

Даяаршил хэмээх өнөө цагийн өнгө төрх өөр болж. Монголчууд бидний амьдралд эерэгээр ч, сөргөөр ч олон талаар нөлөөлж бидний хүсээгүй үр дүнг ч авчирж байна.

Монгол хүний язгуур менталитет өөр болох нь. Энэ нь үнэнийг худал болгож, зөвийг буруу болгож, сайхныг муухай болгон харуулах гэж оролдсон, монгол хүний үнэт зүйл, уламжлалыг мартагнуулах гэсэн харь үзэл суртал, номлолын үр дүн гэхээс өөр аргагүй.

Бидний улс гэрийн хөгжилд нөлөөлөх язгуур хүчин зүйл бол хүний хүчин зүйл, хүний хөгжил, түүнд чиглэсэн боловсролын ухаалаг бодлого. Гэтэл ардчиллын он жилүүдэд хүүхэд, залуусын хөгжил, төлөвшил, нийгэмшил бидний хүссэнээс өөрөөр өөрчлөгдөж эрүүл монгол хүн бүхний сэтгэлийг зовоох болов.

Миний мунхаглан бодсоноор, монгол хүний хөгжлийн үндэс нь хүүхэд бүрийг зөв хүн болгон хөгжүүлж төлөвшүүлэх явдал юм гэж үздэг. Монгол хүний хөгжлийн гол гогцоо асуудал энд байна. Монгол улс хөгжихгүй урагшлахгүй байгаагийн нэг үндсэн шалтгаан нь Монгол хүний хөгжил.

Үүнээс үүдээд зөв эцэг эх, зөв багш, зөв эмч, нийгмийн зөв ажилтан, зөв мэргэжилтэн өнөөдөр ус агаар мэт үгүйлэгдэж байна.

Өнөөгийн нөхцөлд эцэг эх, ЕБС, МСҮТ, их дээд сургуулийн багш бид монгол хүнийг хэрхэн хөгжүүлж төлөвшүүлэх ямар зорилго тавиад хэрхэн бүтээж бэлтгэж, ямар зр дүнд хүрч байна

вэ?, Хаана нь бид алдаж байна вэ?, Монгол хүний хөгжил төлөвшил аль шатанд ямар зүйлд алдаад байна вэ?, ямар хүчин зүйл нөлөөлөөд байна вэ?, түүнийг яаж засаж залруулж сайжруулж бусад улс орны жишигт хүргэх вэ? гэдэгт эрүүл ухаантай хүн бүхэн бодол ухаанаа уралдуулах, хичээн чармайх, оролдох санаачлах цаг болсон байна.

Зөв хүн яаж төлөвшдөг вэ?

Нийгмийн энэ асуудлын талаар хүн төрөлхтний түүхэнд олон сэтгэгчид, мэргэд шинжлэх ухааны онол, үндэслэлийг аль хэдийнээ боловсруулаад ном зохиолдоо үлдээснийг бид мэднэ. Хүний хөгжил, төлөвшлийн язгуур үндэс нь 0-6 насанд үндсэндээ тавигдаж, 7-13 насанд дуусдаг.

Энэ тухай онолын үндэс, гол төлөөлөгчид нь:

1. Шведийн эрдэмтэн Ж.Пиажегийн (1896-1980) танин мэдэхүйн хөгжлийн буюу “генетик эпистемологи” онолдоо (хүүхэд 0-2 насандаа мэдрэмж-биеийн хөдөлгөөнд суурилж танин мэддэг, 2-7 насанд үйлдлийн өмнөх шат явагддаг гэж үзсэн),

2. Норвегийн сэтгэл шинжээч Э.Эриксоны (1904-1994) “Психосоциаль онол”-доо (Хүний хөгжлийн үе шат бүрд түүний хөгжлийг удирдан чиглүүлэх зөрчил илэрч байдаг, 0-1 насанд хүүхдэд итгэх эс итгэх зөрчил үүснэ, дотно мэдрэмжээс шалтгаална гэсэн),

3. Америкийн эрдэмтэн Хорвард Гарднерын “Олон талт оюуны онол”-доо (Оюуны 10 чадамжийн суурийг хүүхдэд тодорхой насанд илрүүлж, энэ мэдрэмжүүд дээр тулгуурлан хөгжүүлж төлөвшүүлэх ёстой. Энэ бол байгалын хууль юм гэж үзсэн),

4. Австрийн нэрт сэтгэл судлаач З.Фрейдийн (1856-1939) “Психоанализ” онол (Хүний зан үйлийг Ид, Эго, Супер-эго гэсэн 3 бүрдэл удирддаг, түүнд либидо хүчтэй нөлөөлдөг),

5. Канад, Америкийн сэтгэл зүйч Альберт Бандура (1925-) “Социаль когнитив онол”-доо (Хүний үйл ажиллагааны шалтгаан нь зан үйл, танин мэдэхүйн хүрээ, орчин зэрэг 3 хүчин зүйлийн тасралтгүй харилцан үйлчлэлийн үр дүн, гурамсан нөлөөлөл гэж үзжээ).

Энэ онолыг иргэд, эцэг эхэд хүргэж, оюун тархинд нь ухааруулж, зүрх сэтгэлд нь шингээж, багш бүхэн өөрийн итгэл үнэмшил, философи чиг хандлага, багшлахуйн үйлийн баримжаа болгох гэдэг бас тун нарийн ажил бололтой.

Зөв хүн гэж хэн бэ? Зөв бодолтой, өрөвч нинжин сэтгэлтэй, зөв ёс суртахуунтай, зөв яриатай, зөв үйлдэлтэй, зөв дадал, зан төрхтэй, уламжлал ёс заншлаа мэддэг зөв ёс зүй, хандлагатай, аливаа юманд болох бүтэх гэрэлтэй талаас нь өөдрөгөөр хардаг эерэг сэтгэлгээтэй, эх оронч, бусад хүмүүс, амьтан, ургамал, гэр бүлээ хайрладаг, ажилсаг хөдөлмөрч, өөрийгөө байнга хөгжүүлэх эрмэлзэлтэй зэрэг хүмүүний сайн сайхан чанарууд, үнэт зүйлийг өөртөө төлөвшүүлсэн хүнийг зөв хүн гэнэ. Зөв хүний үндсэн гол шинж нь зөв сэтгэлтэй байх явдал юм.

Амьдралаас сайн сайхныг олж харах, буяны сайн сайхан бодолд чин сэтгэлээсээ автаж, хэнийг ч гэсэн хүндэтгэн мөс, жудагтай эелдэг харилцах, хүн амьтан, мал, ургамал гээд бүхнийг энэрч хайрладаг, бусдад муу санахгүй, хор хүргэхгүй байх, энэрч хайрлах, хэн нэгнийг уучлан өршөөж чаддаг байх, найзаа олох, зовж шаналж буй хүмүүст туслах, шударга амьдрах, бусдыг хэзээ ч алагчлахгүй, илүүрхэхгүй, шунахгүй байхыг зөв сэтгэл гэнэ. Зөв сэтгэлтэй хүн зөв зүйлийг зөв хийж, зөв сайхан амьдрах зам мөр, аз жаргалаа бүтээдэг.

Ийм энгийн зүйлийг өдөр тутмын амьдралдаа мөрдөж чаддаг ийм зөв хүний амьдрах хэв маягийг аз жаргалтай зөв амьдрахуй хэмээнэ.

Монгол үндэсний онцлогийг харгалзсан зөв хүн төлөвшүүлэх зорилтын эхлэлийг 2013 оноос боловсролын бодлого болгон тавьж хэрэгжүүлэх ажил хийсэн нь сайшаалтай зүйл байсан. Учир дутагдалтай ч гэсэн “Зөв Монгол хүүхэд” үндэсний хөтөлбөр улс төрийн шалтгаанаар хэрэгжүүлэх ажил саармагжлаа. Учир дутагдалтай гэсэний учир бол энэ хөтөлбөрийн нэгдэх дэд хөтөлбөрийг “Гэр бүл, эцэг эхийн боловсролын чанарын шинэчлэл” гэх бүлэг дутуу орхигдсонд байсан юм. Учир нь гэр бүлийн орчин, эцэг эхийн хүмүүнжүүлэн сургах боловсролын түвшин, тогтсон ужиг хандлагыг сайжруулж өөрчлөхгүйгээр монгол хүний хөгжил, төлөвшилд ямар ч ахиц гарахгүй.

Ер нь хүний хөгжилд нэгэнт бага насанд нь төлөвшиж тогтсон ёс суртахууны суурь хандлага, ухамсрын түвшинг өөрчлөнө гэдэг маш төвөгтэй, бараг боломжгүй гэж социологич, сэтгэл судлаачид үздэг. “Арилгахад хамгийн хэцүү хог бол хүний сэтгэлийн хог юм” гэж 20 жил гудамд цэвэрлэгч хийсэн хүний хэлсэн үг тун ортой юм.

Монгол хүүхдэд “Зөв монгол хүн”-ий хувийн чанар, ёс суртахууныг дутуу төлөвшүүлчихээд хожим нь насанд хүрсэн хойно нь халаглаж амаа барьж байснаас эхнээс нь зөв дэс дараатай хөгжүүлж төлөвшүүлэх нь ухаалаг төрийн бодлого, алсын хараатай менежментийн шинж юм гэж боддог.

Зөв сэтгэлтэй зөв хүнийг бүтээж төлөвшүүлэх гэдэг бол олон талын субъектив хүчин зүйлийн нөлөөллөөс шалтгаалдаг нийгэмшүүлэхүйн нэлээд адармаатай, төвөгтэй, эцэг эх, багш, нийгмийн ажилтнаас тун өндөр боловсрол, ур чадвар, урт удаан хугацаатай нөр их хөдөлмөр

шаарддаг нийгэм—сэтгэл зүйн үйл явц юм байна. Үүнийг маш товчоор тоймлон харуулъя.

Бүдүүвч 1. Зөв хүн төлөвшилийн үе шат, нас



Зөв хүн төлөвших үйл явц эхийн хэвлийд ураг бүрэлдэхээс 12 сарын өмнөөс эхэлдэг бөгөөд зөв сэтгэлийн суурийг 0-2 насанд гэр бүлд тавихаас эхэлдэг (Ж.Пиаже). Авьяас нь мэргэжлийн чадвар эзэмшихэд удамшлын суурь хүчин зүйл болдог. Үндсэндээ 25 нас хүртэл үргэлжилдэг (Э.Эриксон). Зөв хүнийг бүтээх, зөв мэргэжилтний төлөвшүүлэхүй нь гадаад ба дотоод олон хүчин зүйлийн харилцан үйлчлэл, интеграци нөлөөллийн үр дүн юм. Үүнд:

Гадаад хүчин зүйл:

- Боловсролын хүн төвт бодлогын сонголт, шийдвэр
- Боловсролын байгууллагын менежментийн чадавхи
- Хүүхдийн эрхийн талаар эцэг эх, багшийн боловсрол
- Эцэг эхийн үлгэр дууриал, багшийн боловсрол, ур чадварын өсөлт
- Эцэг эх, багшийн хүүхэд хөгжүүлж төлөвшүүлэх арга зүй
- Өнөөгийн эцэг эх, багшийн хандлага, багшлахун арга, арга барилын өөрчлөгдөж шинэчлэгдсэн байдал
- Хүүхэд залуустай ажиллах эерэг арга, хайрын хэл
- Хүүхэд залуусын хөгжил, төлөвшлийн зохистой бэлтгэгдсэн орчин
- Нийгмийн мега, мезо орчны эерэг нөлөөлөл
- Хүн төлөвшилд чиглэсэн зорилтот үйл ажиллагааны үр дүн
- Хүүхдийн тархийг биш, зүрхийг хөгжүүлсэн суурь эхлэл

Дотоод хүчин зүйл:

- Авьяас, түүнийгээ цагт нь нээж хөгжүүлсэн байдал
- 0-2 насандаа сэтгэл зүрхний суурь чанарууд төлөвшсөн эсэх
- Ёс суртахууны чанарууд, хандлагын төлөвшил
- Амьдралын зорилго, стратегээ тодорхойлсон байдал
- Амьдрах ухааны боловсролын түвшин
- Өөрийгөө таньж бодитой үнэлэх чадвар
- сэдэл, сэдэлжүүлэлт
- нийгмийн дотоод чадварууд эзэмшсэн байдал
- мэргэжлээ зөв сонгосон эсэх

Бүдүүвч 2. Зөв мэргэжилтний цогц чадамжийн агуулга

Зөв мэргэжилтний цогц чадамжийн агуулга



Судалгааны зарим дүн

Дархан дээд сургуулийн төгсөх ангийн оюутанд “Зөв хүн байх ухаан” хичээлийг шинээр зааж судлуулсан, тэднээс бие хүний хөгжил, төлөвшил, багш хүнд байвал зохих хувийн чанаруудын талаар санал авч өөрийн үнэлгээ хийлгэж үнэлүүлж ярилцлаа.

Энэ дүнгээс үзэхэд:

- Ямар хүнийг “Зөв хүн” гэдэг талаар ерөнхий ойлголтой байна.

- Зөв хүнийг төлөвшүүлэхүйн үндэс язгуур нь зөв сэтгэл, эерэг арга юм гэдгийг /асуулгад оролцогсдын 100%/ хүлээн зөвшөөрч байна.

- “Зөв сэтгэл” буюу сэтгэлийн боловсролын талаар ойлголт муу, энэ талаар итгэл үнэмшил төрөөгүй, үнэт зүйлийн баримжаа бий болж чадаагүй байна /асуулгад оролцогсдын 72% нь байна/.

- Зан төлөв, хандлагын хувьд өөрийгөө бодитой үнэлж байна. Залхуу байна, хэнэггүй байна гэдгээ асуулгад оролцогсдын 86% нь үнэлсэн байна.

- Ёс суртахууны эрхэм чанарууд буюу нийгмийн харилцааны дотоод ур чадварууд нь зөв мэргэжилтэн бие хүний нийгэмд биеэ зөв авч явах, бусад хүмүүстэй харилцахад шаардагдах нийгэм-сэтгэлзүйн чухал чанарууд мөн. Энэхүү дотоод хүчин зүйлийн суурь чанарууд нь 0-2 насанд гэр бүлд тавигддаг ёстой боловч манай нөхцөлд хүүхдэд бүрэн төлөвшүүлдэггүй нь харагдаж байна.

- Хүүхэдтэй харилцах эерэг арга төлөвшөөгүй, хэвшмэл захиргаадах хатуу ширүүн ханддаг аргаасаа салаагүй, гэр бүлд хүчирхийлэл байх л ёстой зүйл мэт ойлгож байна. Ийм хэвшмэл ойлголт манайд нэлээд нийтлэг байгаа нь тун ноцтой асуудал.

- Мэргэжилтэн багш хүний эзэмшсэн байвал зохих нийгмийн чадваруудын талаар ойлголт хангалтгүй байна. Ярилцаж үзэхэд хэрхэн өөртөө төлөвшүүлэх талаар мэдэхгүй байна.

- Хүмүүнлэг нигүүлсэхүйн боловсрол, хүмүүнжил, харилцааны эерэг аргын талаар багшийн философи тогтсон чиг хандлага, багшлахуйн арга зүй, ур чадвар, арга барилыг эргэж харах, өөрчлөх зүйл их байна. Жишээлбэл, үр дүнд суурилсан сургалтын зорилго, агуулга, арга зүй, үнэлгээний үр өгөөж тун тааруу, Монгол

хөрсөн дээр бууж өгөхгүй, тэр хэрээр үр дүн гарахгүй байгаа мэт санагддаг.

Дүгнэлт

Зөв монгол иргэн хөгжиж төлөвших үйл явц нь тодорхой үе шаттай, тодорхой бэлтгэгдсэн орчин, зөв төлөвшиж хүмүүнжсэн сэтгэлийн боловсролтой, ур чадвартай эцэг эх, багшийг шаарддаг юм байна.

Ер нь гэр бүлийн орчин, эцэг эхийн боловсролын түвшин ихээхэн учир дутагдалтай, судалгаа шинжилгээ, оновчтой зөв шийдэл хүлээсэн бэрхшээлтэй асуудал хэвээр байна.

Ингэхлээр гэр бүл бол зөв хүн төлөвшилд шийдвэрлэх үүрэгтэй субъект бөгөөд гэр бүлийн орчин, эцэг эхийн боловсрол, ур чадвар, хандлага, үлгэр дууриалаас тэнд өсөж хөгжиж төлөвшиж байгаа хүүхдийн хөгжил төлөвшлийн үр дүн шууд шалтгаална. Гэтэл манайд энэ талаар эрх зүйн баримт бичигт тусгасан зөвхөн эхлэл төдий байгаа бөгөөд эцэг эхийн үүрэг хариуцлагыг дээшлүүлэх талаар бодитой нөлөөлөл, дэмжлэг үгүй байгаа нь өнөөгийн хүүхэд залуусын хөгжил хүмүүншлийн доголдлын суурь шалтгааны нэг болж байна.

Их дээд сургууль, МСҮТ-д “Зөв хүн, зөв мэргэжилтэн /зөв багш, зөв эмч, зөв ажилчин, зөв иненер/ байхын үндэс, ёс зүйн талаар хэт онолдсон биш, залуусын ой тойнд, амьдралд ойр хичээлийг “Хүний хөгжил” хичээлийн агуулгад багтаан зааж баймаар юм гэсэн саналыг дэвшүүлж байна. Энэ бол эдүгээ цагийн манай нийгмийн эрэлт хэрэгцээ, шаардлага болов.

“Зөв сэтгэл” байвал төрийн боловсролын ухаалаг бодлого, эцэг эх, багшийн хандлага, сэтгэлгээ, арга барилыг өөрчлөн шинэчлэх философи чиг хандлага, эрх зүй, менежмент, эдийн засгийн дорвитой амьд ажлаар зөв Монгол хүн, зөв мэргэжилтнийг бэлтгэн төлөвшүүлэх бүрэн боломж бий.

Зохиогчийн тухай:

Намсрайн Тэгшжаргал. УБДС төгссөн. Боловсролын удирдахуйн доктор (Ph.D), дэд профессор. Судалгааны чиглэл нь бага насны хүүхдийн хөгжил төлөвшил, хүмүүнжил, хүүхэд залуусын ажил хэрэгч өрсөлдөх чадвар.

Ном зүй, ишлэл

1. Хьелл.Л., Зиглер.Д., (2000) Теория личности. Санкт-петрбург. Изд. “Питер”, Серия “Мастера психологии”
2. Зигмунд Фрейд: Бие хүний психодинамик онол
3. Альберт Бандура: Социаль когнитив онол
4. Эрик Эриксон: Бие хүний хөгжлийн “Эго” онол
5. Жан Пиаже: Хүүхдийн оюун ухааны хөгжлийн онол
6. “Зөв Монгол хүүхэд” үндэсний хөтөлбөр. 2013
7. Тэгшжаргал.Н. (2008) Шинэ зууны оюутан
8. Тэгшжаргал.Н. (2013) Хүүхдийг хүмүүншүүлэхүйн менежмент
9. Тэгшжаргал.Н. (2018) Багшлахуйн эрдэм
10. Тэгшжаргал.Н. (2020) Зөв хүн байх ухаан